



Rule by Law as a Historical Tradition of Mongolian Statehood

Danzan Lundeejantsan

Sc.D, Professor, Chair of the Academic Council, Shihihutug University

E-mail address: lundeejantsan@gmail.com

Received: 20 January 2026

Revised: 15 March 2026

Accepted: 23 March 2026

Published online: 30 March 2026



ABSTRACT

This article examines the political and legal nature of human beings; the heritage and traditions of Mongolian legal thought; the Great Yassa as a core value of Mongolian legal consciousness; and its role as the fundamental law of the Great Mongol State. It further analyzes the core values of Mongolian statehood and legal thought—justice, the rule of law, the coherence and systematic nature of legal regulation, continuity and succession, and the conceptual emphasis on protecting and respecting nature—alongside the democratic Constitution of Mongolia and its significance. The scholarly novelty and contribution of the article lie in its attempt to synthesize and clearly articulate the interconnections among Mongolian statecraft, state law, legal thought, and the heritage and value system of traditional legal norms.

Keywords: law, legal norms, legislation, legal thought, the Great Yassa, fundamental law of the state, constitution, constitutionalism, tradition of legal thought, continuity and succession of legal thought.

Хуулиар засаглахуй нь Монголын төрт ёсны түүхэн уламжлал болох нь

Данзан Лүндээжанцан

Шихихутуг их сургуулийн Эрдмийн зөвлөлийн дарга, Доктор (Sc.D), профессор
lundeejantsan@gmail.com

ХУРААНГУЙ

Хүмүүний улс төрлөг, эрх зүйн мөн чанар. Монголчуудын хууль цаазын сэтгэлгээний өв, уламжлал”, “Их засаг” монголчуудын хууль эрх зүйн сэтгэлгээний үнэт зүйл болох нь, Их засаг-Их Монгол улсын төрийн гол хууль байсан тухай, Монгол Улсын төрт ёс, хууль эрх зүйн сэтгэлгээний үнэт зүйлс: шударга ёс, хууль дээдлэхүй, хууль эрх зүйн зохицуулалтын цогц байдал, уялдаа холбоо, залгамж чанар, байгаль эхээ хайрлан хамгаалах үзэл баримтлал, Монгол Улсын ардчилсан Үндсэн хууль, түүний ач холбогдол.

Өгүүлэлд монголчуудын төр ёс, төрийн хууль, эрх зүйн сэтгэлгээний уялдаа, холбоо, төрийн хууль цаазын өв уламжлал, үнэт зүйлсийг хураангуйлан тодорхойлох оролдлого хийсэнд өгүүллийн шинэлэг тал, ач холбогдол нь болно гэж үзэж байна.

Түлхүүр үгс: Хууль, хууль цааз, хууль тогтоомж, хууль эрх зүйн сэтгэлгээ, Их Засаг хууль,

төрийн гол хууль, үндсэн хууль, үндсэн хуульт ёс, хууль эрх зүйн сэтгэлгээний уламжлал, залгамж чанар

ОРШИЛ: Хүн-нийгэм, хүн-хүн, хүн-байгаль эхийн гурвалсан харилцааны соёл, хэм хэмжээ, дэг журам бүрэлдэн тогтсон түүх нь хууль цааз, эрх зүйн сэтгэлгээний түүхийн суурь мөн чанарыг илэрхийлдэг. Хүн төрөлхтөн нийгэмшин амьдрах явцдаа хамтын амьдралыг зохион байгуулах зайлшгүй хэрэгцээнээс төр, засаглал, хууль цаазын тогтолцоог бүрдүүлж ирсэн нь Аристотель, Макс Вебер нарын улс төр, нийгмийн онолд тодорхой тусгалаа олсон байдаг.

Энэхүү судалгааны зорилго нь Монголын төр ёс, хууль цаазын сэтгэлгээний түүхэн уламжлал, түүний дотор Чингис хааны “Их Засаг” хуулийн үзэл санаа, агуулга, дэлхийн хууль цаазын хөгжилд оруулсан хувь нэмрийг онолын болон түүхэн эх сурвалжид тулгуурлан шинжлэхэд оршино.

Судалгааны таамаглал нь: Монголын хууль цаазын уламжлал нь нүүдэлчин соёл иргэншлийн онцлогт суурилсан, жам ёсны бөгөөд өнөөгийн үндсэн хуульт ёс, ардчилсан төрийн хөгжлийн оюуны эх ундарга болсоор ирсэн гэсэн санаанд тулгуурлав.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ: Судалгаанд түүхэн-харьцуулсан, эх сурвалжийн шинжилгээний, анализ-синтезийн болон онолын ерөнхийлөн дүгнэх аргазүйг ашиглав. Судалгааны хэрэглэгдэхүүнд эртний түүхч, шастирчдын бүтээл (Макризи, Мирховенд, Ибн Баттута, Рашид ад-Дин), орчин үеийн монгол судлаачдын судалгаа (С.Нарангэрэл, Ж.Болдбаатар, Б.Чимэд, Д.Лүндээжанцан нар), хууль цаазын түүхэн баримт бичгүүд (“Их Засаг”, “Халх журам”, “Монгол, Ойрадын хууль”, 1992 оны Үндсэн хууль гэх мэт)-ийг хамрууллаа. Судалгаа нь чанарын судалгааны шинжтэй бөгөөд Монголын төр ёс, хууль цаазын хөгжлийн үе шат бүрийг хамруулан авч үзсэн болно.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН: Судалгааны үр дүнд хууль цааз нь хүний нийгмийн оршихуйн зайлшгүй хэрэгцээнээс үүссэн дээд зэргийн зохицуулалтын хэлбэр болох нь тогтоогдов. Эртний Шүмэрийн Ур-Намму, Вавилоны Хаммураби, Энэтхэгийн Манугийн хуультай эн зэрэгцэхүйц ач холбогдол бүхий “Их Засаг” хууль нь Монголын төдийгүй дэлхийн хууль цаазын түүхэнд онцгой байр суурь эзэлдэг болохыг эх сурвалжууд нотолж байна.

Их Засаг хуулиар төрийн байгуулал, хааны эрх мэдэл, засаг захиргаа, эрүү, иргэний харилцаа, байгаль хамгаалал, дипломат ёс, шашны бодлого зэрэг нийгмийн бүх харилцааг бүхэлд нь эрх зүйн зохицуулалтад оруулсан нь түүнийг цогц хууль тогтоомж болгож байжээ.

Мөн эмэгтэйчүүдийн эрх, хүний амь бие, эд хөрөнгийн халдашгүй байдлыг хамгаалсан заалтууд нь тухайн цаг үедээ дэвшилтэт, хүмүүнлэг шинжтэй байсныг судалгааны үр дүн харуулж байна.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ: Их Засаг хуулийн үзэл санаа нь зөвхөн Монголын эзэнт гүрний үед бус, дараагийн бүх түүхэн үе шатанд (Их Юань улс, Богд хаант Монгол улс, БНМАУ, ардчилсан Монгол Улс) төрийн хууль цаазын бодлогын суурь чиг баримжаа болсоор иржээ. Энэ нь Монголын хууль цаазын уламжлал тасралтгүй, залгамж чанартай хөгжсөний тод илрэл юм.

Монголын хууль цаазын сэтгэлгээний гол үнэт зүйл нь шударга ёс, хууль

дээдлэх ёс, ял шийтгэлийг гэм хорд нийцүүлэх зарчим, байгаль эхийг хайрлан хамгаалах үзэл санаа байсаар ирсэн нь Платон, Аристотель, Ж.Локк, Монтескье нарын хууль ёсны төрийн тухай онолтой агуулгын хувьд нийцэж байна.

1992 оны Үндсэн хууль нь энэхүү түүхэн уламжлалыг орчин үеийн ардчилсан үнэт зүйлтэй уялдуулан баталгаажуулж, хүний эрх, эрх чөлөө, төрийн эрх мэдлийн хуваарилалт, шүүхийн хяналтыг хангах замаар Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлсэн байна.

Үндсэн агуулга. Хүн-нийгэм, хүн-хүн, хүн-байгаль эх гэсэн гурвалсан харилцааны соёл, хэм хэмжээ, дэг журам бүрэлдэн тогтсон түүх нь хууль цааз, эрх зүйн сэтгэлгээний түүх болно. Энэ түүхэн үйл явцад хүний нийгэмшин амьдрах, хэн нэгний хүч чадал эрх мэдлийн эрхшээлд (эсхүл эрхшээх) зохион байгуулагдан аж төрөх буюу хүний төрөлхийн “улс төрлөг” мөн чанар илэрдэг бөгөөд үүнийг Аристотель (“Улс төр”), хожим Макс Вевер (“Улс төр мэргэжил, хувь тавилан болох нь”) нар “Хүний нийгмийн уугуул мөн чанар бол оршихуйн тулд хамтран аж төрөх, хамтрахуйн утга учир нь зохион байгуулалт”, өөрөөр хэлбэл, хүн амьдрахын тулд хүмүүний аль нэгэн олонлог (овог, аймаг, өрх гэр бүл, улс үндэстэн г.м.)-т харьяалагдан, хууль цааз, ёс журам, зан заншлыг нь даган засаглагдан (засаглаж) аж төрөхөөс өөр замгүй гэж тодорхойлжээ. Үүнийг хүний, хүний олонлогийн өнгөрсөн, одоогийн нь туршлага, ой санамжид нь суурилсан оршихуйн арга ухаан гэх бөгөөд эрх зүйн сэтгэлгээ гэж ч нэрлэдэг байна. Хүн-хүн, хүн-нийгэм-төр, хүн байгаль гэсэн харилцааны зохицуулалт, “тохируулалт” буюу “хэм хэмжээ”-ний дээд илэрхийлэл нь хууль байдаг. Толь бичиг /Википедиа/-т тодорхойлноор хууль бол бүх нийтээр даган мөрдөх дүрэм, нийгмийн бүх гишүүд хоорондын харилцаа, үйл ажиллагааг зохицуулдаг дүрэм, журам юм. “Хууль-лат. lex, англ. Law-хууль тогтоох байгууллагын онцгой журам буюу ард түмэн хүсэл зоригоо илэрхийлсэн ард нийтийн санал асуулгаар баталсан, хууль зүйн дээд хүчин чадалтай, нийгмийн амьдралын нэн чухал харилцааг зохицуулсан хууль тогтоомж” (*С.Нарангэрэл 2021*).

Түүхчид анхны хэлбэршсэн хуулийг МЭӨ 2100 оны үеийн Шүмэрийн Ур Намму нийтлэлээрээ алдаршсан Хаммураби хааны нэрт хууль гэж үздэг. Хүний нийгмийн язгуур мөн чанар болсон засаглагдан зохион байгуулалттай аж төрөхүйн үндсэн хэлбэр нь төр улс, засаглахуйн бодит хуульчлагдсан үндсэн хэлбэр нь төр гэж үздэг байна. Хүмүүнд засаглал, захиргаа хэрэгтэй, засаглал, захиргаанд хууль хэрэгтэйн холбоо ингэж үүсдэг жишээтэй ажээ. Хүмүүн, төр, хуулийн бие биеэ нөхцөлдүүлэх холбоог бүр эртний сэтгэгчид Гераклит, Сократ, Платон, Аристотель нар “Хүнд төр хэрэгтэй бол, төрд өөрт нь хууль гарцаагүй хэрэгтэй”, “Хаана хууль байна тэнд төр ёс байна”, “Хуульд захирагддаг байх нь төрийн нэг ёсны атрибут” гэх зэргээр тайлбарласан байдаг ажээ. Учир иймд “Хүний түүх бол улс үндэстний түүх, улс үндэстний түүх бол төрийн түүх, төрийн түүх бол хууль цаазын түүх” болдог учиртай ажээ.

“Хууль цааз, ёс журмыг эрхэмлэн дээдэлж сахих, төр улс, иргэний гол гол хэргүүдээ хуульд захируулан шийддэг нь Монголын ард түмэн, монгол төрийн нандин уламжлал нь юм. Чингис хаан хууль цаазыг үл биелүүлбэл төр улс сулран мөхнө гэж үздэг байснаас хууль зарлигийг хянан хэрэгжүүлэх тушаалтныг томилсон. Улсын иргэн бүр дээд, доод гэлгүй хуульд л захирагдана. Хуулиа

дээдлэгтүн, хуулиа сахигтун гэж Чингис үргэлж сургадаг байж (*Ч.Далай 2002*).

Монголчуудын хууль цаазын ухамсар сэтгэлгээний чиг баримжаа, түүх уламжлалын “тодоос тод сонин” үнэт зүйл бол Суут богд Чингис хааны “Алд бие минь алжааваас алжаатугай, ахуй төр минь бүү алдраг” алтан сургаал, түүний бодож санаачилсан “Их Засаг” хууль юм. “Их засаг хуулийн гол үзэл баримтлал нь:

-хааны /төрийн/ эрхийг дээдлэх, хаанд үнэнч байх

-хуулийг сахин биелүүлэх

-эзэн харьяатын ёсыг чанд сахин биелүүлэх-ахмадыг хүндэтгэх, нялхсыг асрах

-эе эвийг сахих зэрэг асуудалд чиглэж байсан (*Ч.Далай 2002*).

Их засаг бол бас зөвхөн цөөн монголчуудын төдийгүй, нийт хүмүүн төрөлхтний төр барихуй, хууль эрхийн сэтгэлгээний үнэт зүйл болохыг эрдэмтэн судлаачид тэмдэглэсэн нь цөөнгүй. Их засаг хууль бол дэлхийн соёл иргэншлийн түүхнээ бүхэл бүтэн нийгэм, улс төрийн байгуулал бүрэлдэн тогтооход томоохон үүрэг гүйцэтгэсэн эртний Вавилоны Хаммурабийн хууль, Энэтхэгийн Манугийн хууль зэрэг алдартай хуулиудтай эн зэрэгцэхүйц ач холбогдолтой цааз эрхэмжийн нэн чухал баримт бичиг мөн. Учир нь энэ хуулийн зарчим, үзэл санаа зөвхөн монгол нутаг төдийгүй ертөнцийн талыг эзэгнэсэн их гүрний хэмжээнд үйлчилж байсны хувьд дэлхийн хууль цаазын түүхэнд баларшгүй ул мөрөө үлдээсэн бүлгээ” (*Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан 2021*).

“Их Засаг” хуулиар төрийн хэлбэр, дэглэм, хааны эрх мэдэл, төрийн байгууллагын зохион байгуулалт, эрх, үүрэг, ажиллах журам, засаг захиргааны хуваарь, газар нутаг, байгаль хамгаалал, эзэн албатын ёс, алба татвар, ёс заншил, эрүүгийн бодлого, ял ногдуулах ба эдлүүлэх зарчим, журмыг тодорхойлон тогтоожээ. Тухайлбал, Их Засаг хуульд гадаад харилцааны цааз, цэргийн цааз, шүүх, шашны цааз зэргийг бүхэлд нь “Төр засах цааз”-д, харин ахуй заншил, иргэд хоорондын харилцаа, сургаал сургамж, тэтгэвэр, тэтгэмж, өмч хөрөнгө, өв, залгамжлал, гэрлэлт, гэр бүл, арилжаа худалдааны шинжтэй хэм хэмжээнүүдийг “Иргэний аж байдлын цааз”-д хамруулснаас гадна Их Монгол Улсын төрийн бүрэн эрх, нийгэм төрийн байгууламжийг бэхжүүлэх, түүнчлэн хуулиар тогтоосон бүх хэв журмыг гэмт халдлагаас хамгаалах “Эрүүгийн цааз”-ыг тодорхойлон тогтоосон, өөрөөр хэлбэл, нийгмийн харилцааг бүхэлд нь эрх зүйн зохицуулалтад оруулжээ.

Их Засаг хууль хийгээд Их Монгол Улсын төрийн гадаад бодлого нь хил хязгаарын аюулгүй байдлыг хангах, гадаадын халдлага довтолгооноос сэргийлэх, өрнө дорнын улс оронтой улс төр, эдийн засаг, соёлын хэлхээ холбоогоо өргөтгөх, мэдээллийн солилцоог идэвхжүүлэх, улс орноо засан тохинуулах гээд хожим хойчдоо төрийн бодлогын ноён нуруу нь болсон олон санаа шингэжээ. Элчин төлөөлөгчдийн эрх ямба, аюулгүй байдлыг баталгаажуулах, халдашгүй байдлын “Гэрэгэ” тэмдэг олгох зэргээр өнөөгийн дипломат ёсны соёлын төлөвшилтөд монголчуудын оруулсан үнэтэй хувь нэмэр нь юм.

“Гадаад харилцаа, дипломат ёс, аюулгүй байдлын зэрэгцээ эх дэлхийгээ бүхэлд нь хайрлан хамгаалж уул, усаа “амилуулан” шүтэж халдах, хандах зан үйлийн хорио цээрлэлийг тогтоон мөрдүүлж, тэр бүхнээ нийт иргэн, үр хойчдоо ухааруулан мэдрүүлж, амьдрал ахуйгаа байгаль орчинтойгоо нягт хослуулан зохицуулж ирсэн өвөрмөц арга уламжлал юм.” О.Амархүү. Байгаль хамгаалах

энэхүү монгол уламжлалыг алдалгүй сахин авч явах нь үндэсний төдийгүй нийт хүмүүнлэгийн ой санамжид хадгалагдах учиртай зүйл юм.

Хүн төрөлхтний түүхэнд төрийн хууль цаазад эмэгтэйчүүдийн эрхийн асуудлыг анхлан тусгасан нь Их Засаг хууль гэх үндэс бас байна. Тухайлбал, Гуулин улсын судраас профессор Сумьяабаатарын олсон баримтад: “Зэрэг захирагч хийгээд цэргүүд хүчиндээ дулдуйдан, шинэ дагасан аливаа хот, гацаанаа эмс хийгээд охидтой хүч түрэн гэрлэж болохгүй” хэмээн заасан байна. Эрдэнэт хүмүүний амь бие, эд хөрөнгө, эрүүл мэндийг сахин хамгаалах нь Их засгийн “амин сүнс” нь байсныг онцолбол зохистой. Эдгээрийг зөрчвөл ялын дээд хэмжээ оноохоор хуульчилжээ.

Ийнхүү Их Засаг хууль болон Их Монгол Улсын хууль цааз нь тухайн нийгмийн зайлшгүй бодит хэрэгцээ шаардлагаас үүдэн гарсан, хүмүүнлэгийн харилцааны олон талыг хамруулан эрх зүйн зохицуулалтад оруулсан шинжтэй байснаараа жам ёсны хууль байжээ. Ж.Болдбаатар нарын тодорхойлсноор “Их Засаг хууль бол дэлхийн соёл иргэншлийн түүхнээ бүхэл бүтэн нийгэм, улс төрийн байгуулал бүрэлдэн тогтооход томоохон үүрэг гүйцэтгэсэн эртний Вавилоны Хаммурабийн хууль, Энэтхэгийн Манугийн хууль зэрэг алдартай хуулиудтай эн зэрэгцэхүйц ач холбогдолтой эрхэмжийн нэн чухал баримт бичиг мөн. Учир нь энэ хуулийн зарчим, үзэл санаа зөвхөн монгол нутагт төдийгүй ертөнцийн талыг эзэгнэсэн их гүрний хэмжээнд үйлчилж байсны хувьд дэлхийн хууль цаазын түүхэнд баларшгүй ул мөрөө үлдээсэн бүлгээ”.

Чингис хааны “Их Засаг” хууль нь түүний байгуулсан эзэнт гүрний амьдралд асар их үүрэгтэй байж, Монголчуудын болон эдлэгдсэн бусад ард түмний амьдралд бүх талаар нөлөөлж, Дэлхий дахины үндсэн гол хууль цаазын үүргийг удаан хугацаагаар гүйцэтгэж иржээ. Жишээлбэл, Оросын Вант улсуудын хувь заяаг гартаа атгаж байсан Алтан Ордны Улсад энэ хуулиас өөр бичигдсэн хууль байгаагүй юм гэж Оросын эрдэмтэн В.А.Рязановский бичсэн байна. “Их Засаг” хууль Цагадайн Улсад XV-XVI, Зүчийн Улсад XVI зуун хүртэл мөрдөгдөж байв.

Их Засаг хуулийг 1206 оны Их Хуралдайгаар үндсийг нь баталж, 1210, 1218 онуудад нэмэлт, өөрчлөлт оруулснаар 1227 онд засварлаж дуусгасан гэж эрдэмтэд үздэг.

Макризи, Мирхогенд, Ибн Баттута, Варган, Рашид ад-Дин нарын эртний түүхч, шастир туурвигчид Их Засаг хуулийн тодорхой хэсгийг тэмдэглэн үлдээж бидэнд хүргэжээ. Хятадын эх сурвалжид энэ хуулийг эш татсан, дурдсан материал ч нэмж олдсоор.

Тухайлбал: Макризи, Их Засаг хуулийн “садарлан самуурах, үймээн дэгдээх, санаатай худал хэлэх, ид шид үйлдэх ...” зэрэг олон үйлдлийн төлөө цаазын ял оноох, тэрчлэн “эд бараа аваад дампуурвал, дахин бараа авч дахин дампуурвал, дараа нь дахин бараа авч дампуурвал гурав дахь удаад нь цаазлах, аль ч шашныг эн тэнцүү үзэх, хамаг ноёд өөрийн эзэн хаанаас ондоо хүнтэй харьцахыг хориглох, шуудан өртөө байгуулах, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих” зэрэг олон дэг журам тогтоосон 26 зүйлийн олж мэдээлсэн байх юм.

Мөн тэрчлэн Мирховенд цэрэг дайн ан цавын үед цалгар назгайгаасаа алдаа гаргасан үед оноох шийтгэл, гэмт хэргийн улмаас цаазын ялаар шийтгүүлсэн

этгээдийг өр төлөөснөөс чөлөөлөх (лалын шашинтан хүний төлөөс 10 алтан зоос, хятад хүний төлөөс 1 илжиг гэх мэт), Ибн Баттута “адуу хулгайлсан этгээд адууг эзэнд нь өгөхдөө 9 адуу нэмж өгөх, хэрэв төлөх хөрөнгөгүй аваас хүүхдийг нь авах, хүүхэдгүй бол өөрийг нь алах” зэрэг хэм хэмжээ тогтоож байсан ба Вартаны олсон болон бусад эх үүсвэрээс тодорсон нь нэмэгдсээр “Их Засаг” хууль нь 40 орчим зүйлтэй байсан нь тодорхой болж байна, Үүнээс гадна бичмэл Их Засаг хуулийн зэрэгцээ Билиг” буюу Хааны аман зарлигаас бүрдсэн зүйл нэмэгдэж, 170 орчим зүйл, хэсэг болно гэж үздэг доктор Эрэнжин Хара-Даваа нарын эрдэмтэд ч бий. МУИС-ийн ХЗС-ийн эрдэмтдийн судалгаагаар Их засгийн заалтуудыг агуулгаар нь 12 бүлэг, 216 зүйл болгон ангилжээ (*И.Дашиям нар 1995*).

Их засгийн үзэл санаа, төрийн гол хууль байсан, мөн нийгмийн амьдралын бодит хэрэгцээ, шаардлагаас урган гарсан жинхэнэ жам ёсны жишиг нь Их Монгол Улс, Юань гүрэн, Богд хаант Монгол Улс, БНМАУ, Монгол Улс гээд Монголын буурал түүхийн бүх үед төрийн хуулийн бодлого үйл ажиллагааны нэгэн эх ундарга, чиг баримжаа нь болж иржээ. Тухайлбал, Их Юань улсын хууль цаазын бичиг (1271 он); “Ертөнцийг засах магад хууль” буюу “Хаан төрийн ертөнцийг засах магад хууль” (1312 он); “Их Юанийн нэвтэрхий хууль” (1322 он); Улс төрийн бутралын гэж нэршигдсэн (ойролцоогоор 1370-1660-аад он) үеийн “Монгол, Ойрадын хууль” (1640 он); “Алтан хааны цаазын бичиг”; “Гадаад Монголын хууль зүйн бичиг” (1785 он); Олноо өргөгдсөн Монгол Улсын (Богд хаант Монгол Улсын) үеийн “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйн бичиг” (1915-1918он) зэрэгт түүхэн тодорхой зарчмын үүднээс хийгдсэн харьцуулсан судалгаанаас үзэхэд эдгээр нь нийгмийн амьдралын бодит хэрэгцээ шаардлагаас үүдэн гарсан жинхэнэ “жам ёсны хуулиуд байжээ. Бүр манжийн ноёрхлын үеийн монголчууд өөрсдөө бүтээсэн хууль цаазын бичиг “Халх журам” (1789)-д л гэхэд “... туурга тусгаар байдлаа алдсан үедээ ч төр, эрх зүйн монгол уламжлалаа хэвээр хадгалж, өвлөн үргэлжлүүлэхийг эрмэлзэн тэмцэж байсныг”, түүнчлэн энэ баримт бичиг “монголчууд эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн төвшнөөр бусад улс үндэстнээ доогуур биш байсан”-ыг нотолж байна (*Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан 2021*).

Богд хаант Монгол улс (Олноо өргөгдсөн Монгол улс)-ын хууль цаазын бодлогын үндсэн зорилго нь Манжийн засаг захиргаа, хууль цаазыг халах үйл ажиллагааг үе шаттай хэрэгжүүлж үндэсний хууль цаазын уламжлалыг шингээсэн “Хууль дүрмийн дэвтэр бичиг “Жинхэнэ дагаж явах хууль дүрэм эрх зүйн акт,” зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг” /цаашид ХЗБ гэх/-ийг гарган хэрэгжүүлж байжээ. ХЗБ-ийн нэгдүгээр дэвтэрт Олноо өргөгдсөн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зохион байгуулалтыг, хоёрдугаар дэвтэрт төрийн яамдад ажиллах албан хаагчийн орон тоог хуульчилсан бол гуравдугаар дэвтэрт яамдын зохион байгуулалт хийгээд эрх зүйн байдлыг, дөрөв, тавдугаар дэвтэрт хэргэм зэрэг залгамжлах ёсыг хуульчлан тодорхойлжээ. Монгол Улсын засгийн газар нь Дотоод яам, Гадаад яам, Цэргийн яам, Сангийн яам, Шүүх яам, Улсын хурлын яамнаас бүрдэж байсны гадна Улиастай, Ховд, Хиагтад аймаг хошуудын хэрэг хамааран шийтгэх сайдын газар ажиллах болсон байна. Өмнө дурдсан яамдын тэргүүн, дэд тэргүүн, дэд сайдууд нь тус тусын яамны бүх хэргийг эрхлэн захирч, Засгийн газрыг бодлогыг тодорхойлж, өдөр тутмынх нь үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэйн дээр эрхэлсэн түшмэл, дэс түшмэлүүд нь

тус тусын яамны хэлтсүүдийг удирдан бүх ажлаа сайдын өмнө хариуцна. Ийнхүү ХЗБ-г төрийн яамд, тэдгээрийн эрх, үүрэг, ажиллах орон тоог тогтоожээ.

Ардын засгийн буюу БНМАУ-ын үед улс орны тусгаар тогтнолын үндэс-эдийн засаг, аж ахуйгаа өөд татах, үндэсний төр засгаа төвхнүүлэх, манжийн ноёрхлын хор уршиг болсон эрин зууны хоцрогдлыг арилгах, нийгмээ соёлжуулах, улмаар тусгаар тогтнолоо баталгаажуулахад томоохон алхам хийгджээ. Гэхдээ энэ зам шулуун дардан байгаагүй юм. Монголд хаант засаг, хамжлагат ёсыг халсан БНМАУ-ын анхдугаар Үндсэн хууль үндэсний ардчилсан үзэл санааг шингээсэн хууль байсан бөгөөд улс оронд Бүгд найрамдах засаглалын эхлэл нь болсон юм. Гэвч гаднын /Коминтерн, ЗХУК Болшевик/ дарамт шахалтаар анхдугаар Үндсэн хуульд туссан ангич үзэл санаа аажмаар лавширсаар /1940 оны, 1960 оны Үндсэн хуулиуд/ Монголд нэг нам, монгол хүний мөн чанарт харш үзэл суртал ноёрхсон, хувийн өмчийг үгүйсгэсэн “хүн сурталт захиргаадалтын дэглэм” тогтсон нь ардчилал, хууль ёсыг завхруулсан, хүнд гарз хохирол /хэлмэгдүүлэлт г.м/ гажуудал бэрхшээл дагуулсан, нийгмийн хөгжлийн хямралт, царцмал байдалд хүргэсэн билээ. Гэхдээ БНМАУ-ын социалист хэв маягийн үндсэн хуулиудыг зөвхөн гажуудал дагуулсан хуулиуд байсан гэх нь бас нэгэн ёсны туйлшрал болно. Үндсэн хуулиудад тодорхойлсон “нийгэм журамд дэвшин орохын учир улс орноо хөрөнгөтний бус замаар хөгжүүлэхийг хангах” /1940/, “социализмын материал техникийн баазыг байгуулах” /1960/ зорилтуудыг хэрэгжүүлэх явцад улс орны тусгаар тогтнолыг бэхжүүлж олон улсын хамтын нийгэмлэгийн баталгааг нь бүрдүүлэх, улс төрийн харьцангуй соёлжсон тогтолцоог төлөвшүүлж үндэсний төр засгаа бэхжүүлэх, иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах, сурч боловсрох, ажиллах, хөдөлмөрлөх эрх чөлөөг нь баталгаажуулах, нийгмээ бүхэлд нь соёлжуулах, улс орныхоо эдийн засаг аж ахуйг хөгжүүлэхэд түүхэн алхам хийгдэж Монгол Улс тусгаар тогтносон, эдийн засгийн олон салбартай, орчин цагийн соёлжсон улс орон болон хөгжсөнийг үгүйсгэх аргагүй.

Бүхэлдээ Монголын төр ёс, хууль цаазын төлөвшилд түүхэн тодорхой байр сууринаас харьцуулсан судалгаа хийж үзвээс Монгол төрийн хууль цаазад үеэс үед уламжлагдсан үнэт зүйлсийг дараах байдлаар тодорхойлж болно гэж үзнэ. Үүнд:

Нийт иргэндээ эрх ямба, эд хөрөнгө, угсаа 1. гарвалиас нь үл хамааран алагчлалгүй, тэгш шударга, нигүүлсэнгүй хандах шударга ёсны суртахуун;

Марко Поло: “...Чингис хааны засаглал шулуун шударга, хүн ардаа ээлтэй, энэрэнгүй үзсэн бусад орны хүн ард ч түүнтэй өөрсдөө ирж нийлэн, нэгдсээр байв. Нэг мэдэхэд түүнийг дагалдагсад, дэмжин талархагсад газар, дэлхийг хучин бүрхсэн нь үй түм болсныг үзээд тэр бээр дэлхийг байлдан дагуулж, эзэмшин эрхшээхээр зоригложээ”. Энд Их Юань Улсын “Нэвтэрхий хууль”-д “Далаас дээш, арван таваас доош насны, эсхүл эмгэг өвчтэй хүний ялыг золиогоор солих, мөн эцгийн хийсэн ялыг хүүд, ахын хийсэн ялыг дүүд халдаах, ялтанд цааз хуульд зааснаас гадуур харгис хатуу эрүү шүүлт хэрэглэх, ялтныг байцаах ажиллагааг шөнийн цагт үргэлжлүүлэхийг хатуу хориглосон” зэргийг дурдаж болно.”

Жувейни: “Монголчуудын хууль цаазын шударга хичээнгүй байдлыг хэлбэл гайхалтай хэмжээнд хүрчээ. Арван түмэн цэргийг ерөнхийлөн захирдаг жанжин байлаа ч хамаагүй, хэрэв алдаа, осол гаргасан байвал хаанаасаа хэдий

хол алслагдсан ч байг, хаан нь морьт хуягаасаа ганцханыг илгээвэл даруй тогтсон арга хэлбэрээр өнөөхийг нь шийтгэж чадна. Жишээлбэл, толгойг нь авна гэсэн бол толгойг нь огтолно. Алтыг нь авна гэсэн бол биеэс нь алтыг авч одно”.

Академич **С.Нарангэрэл**-ийн хэлснээр Монгол төрийн хууль цаазын хамгийн эрхэм нандин уламжлал, үнэт зүйл нь шударга ёсны ёс суртахуун болж иржээ. “Шударга ёсыг монгол гэрийн тоонотой адилтгаж болно. Тооногүй гэр монгол гэр болж чадахгүйтэй адил аливаа хүнд авьяас мэдлэг байгаад ч шулуун шударга, ариун явахгүй бол хүний мөс чанараа алдана. Шударга ёс алдагдвал улс орон ч өөдлөн дэвжихгүй.” Шударга байхын ёс суртахуун бол Монгол үндэсний хууль цаазын ухамсар, сэтгэлгээний хөдөлшгүй ноён нуруу нь болсон үнэт нь зүйл юм.

2. Ял шийтгэл, зэмлэл нь өдүүлсэн хэрэг зөрчлийн гэм хорд нь яв цав нийцсэн, тохирсон байх зарчим;

3. Хууль цааз, зарлигаар тогтоосон дэг журмыг хэлбэрэлтгүй сахих, сахиулах (өнөөгийн хэллэгээр хуулийг дээдлэн сахих) ухамсар сэтгэлгээ, дэг жаяг; Энэ бол үндсэн хуульт ёс, Бүгд Найрамдах засаглалын мөн чанарын зүйл, гол шинж нь юм. “Грек, Ромын нийгэм парламент ёсны үндсэн шинж бол “хууль дээдлэх чанар”, хууль бүхэнд ноёрхох” зарчим бөгөөд хуулийн үнсэн дээр, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах зарчимтай гэж үздэг байжээ. Платон “хууль засаглахгүй байгаа газар төрийн мөхөл холгүй байгааг төвөггүй ажиглаж болно” гэсэн бол Аристотель “Хууль засаглахгүй байгаа газар төрийн байгууллын хэлбэр орших орон зай байхгүй, хууль бүхнийг засаглах ёстой” хэмээн тодорхойлж байжээ. Парламентат ёсны сэтгэгчид Дж.Локк, Ш.Монтесьеке, Ж.Бентам нар ч хууль бүхнээс дээгүүр засаглах учиртай гэсэн байдаг” (*Ц.Товуусүрэн 2024*).

“Ноёд түшмэд, цэрэг дайчид, хөтөч зарц хүртэл тус тусын тушаалаа гүйцэтгэн чадваас мөнх Тэнгэрийн хүчинд их үйлс бүтээх ажгуу. Тиймээс миний сургаалыг мянган онд хувиргалгүй, түмэн үедээ өөрчлөлгүй ургийн ургаараа мөрдөн журамлатугай”. Эдгээр (2, 3) нь шударга ёс суртахуунтай салшгүй холбоотой, хэрэгжих нөхцөл, хэлбэр нь болсон шаардлагууд юм.

4. Хууль цаазын нийгмийн амьдралын бүх хүрээг хамарсан аль болох цогц байдал, өөр хоорондын уялдаа холбоо сайтар хангагдсан байдал (Жишээ нь: Их Засаг, Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг г.м/). Тухайлбал доктор Г.Совдын тодорхойлсноор эл хууль зүйлийн бичиг нь “өөрийн бүтэц үндэслэл, зорилт агуулгын хувьд боловсорч байсан цаг үеийнхээ дотоод, гадаад нөхцөл байдлаас шалтгаалж, феодалын нийгмийн байгуулалтай бусад орны нэгэн адил нийгмийн олон төрөл зүйл харилцааг зохицуулсан нэгдсэн хууль байсан юм” (*Э.Авирмэд, Э.Дашицэдэн, Г.Совд 1997*).

5. Байгаль эх, уул усаа “амилуулан шүтэж”, хайрлан хамгаалах үзэл санаа зэрэг үзэл санаа, зарчмын зүйлүүд. Уул, усаа амилуулан шүтэх үзэл санаа, хүмүүний зан заншил, дэг жаяг. О.Амархүү абугай “Монголчууд соёл, ахуй амьдралын хөгжлийнхөө өнөөг хүртэлх бүхий л үеийн туршид уламжлуулан хадгалж ирсэн нэгэн зүйл бол байгаль орчинтойгоо зөв харьцаж ухаалгаар зохицон аж төрөх зан заншил, ухаарал, хууль цааз, үзэл бодол юм. Эдгээр нь нүүдэлчдийн соёл иргэншлийн шинж төлөвийг дэлхийн улс орнуудад, ялангуяа өндөр хөгжилтэй орнуудад сонгомол загвар болж болох ач холбогдлоороо өвөрмөц онцлогтой” гэж

бичиж үлдээжээ (*О.Амархүү 2022*).

Энд “Алтан хааны цаазын бичиг” (1507-1582 он)-ийн ан амьтныг хамгаалах, мал сүргийг аюулаас аврах заалтууд “Монгол, Ойрадын хууль” (1635 он), “Халх журам”-ын “Рашаан усны эх ундаргыг цэвэр, ариунаар байлгах”, “Хүрээ зассан газар ... хуурай, нойтон мод огтлохгүй байх”, “Нойтон модыг хүрээний захаас хоёр хар цагааны газраас нааших модыг бүү огтол” зэрэг Их Засгаас эхтэй байгалийг хамгаалахтай холбоотой олон заалтыг жишээлж болно.

Дээр дурдсан монгол төрийн хууль цаазын сэтгэлгээний уламжлал нь болж үндэсний ой санамжид дархлагдах учиртай үнэт зүйлсээс нэн чухал нь болох хууль дээдлэх ёсыг онцлох учиртай юм. юм. Үүнийг Үндсэн хуулийн эх баригчид: доктор, профессор, Хөдөлмөрийн баатар Б.Чимид, доктор, Үндсэн хууль судлаач эрдэмтэн судлаачид дараах байдлаар томъёолжээ. Үүнд:

- эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулах харилцааг зөвхөн хуулиар, зарлигаар, хууль тогтоомжийн актаар зохицуулах,
- аливаа хууль, эрх зүйн актууд төрийн гол хуульд нийцсэн байх,
- хүний эрх, эрх чөлөө нь хуулиар баталгаажсан шударга шүүхээр хамгаалагдсан байх,
- Үндсэн хууль, түүнд нийцсэн хууль тогтоомжийг улс даяар нэг мөр ойлгож, нийтээр дагаж мөрдөх,
- Хууль зөрчсөн гэм буруутай хэн боловч хууль зүйн зохих хариуцлага хүлээх. зэргийг дурдаж болно.

Монголын төр улсын түүхийн бүх үед хууль цаазын бодлогын нь ноён нуруу нь болж ирсэн эдгээр үзэл санаа, үнэт зүйл нь ардчилсан Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бүх актуудад шингэн хэрэгжиж байгаа болно.

“Монгол Улсын Үндсэн хууль бүхэлдээ, улсад тусгаар тогтнол, иргэнд эрх чөлөө, хүн амд эрх тэгш байдал, эх оронд зах зээлийн эдийн засаг, төрд ардчилсан дэглэм, орон нутагт өөрөө удирдах ёс, Үндсэн хуульд шүүхийн хяналт ба тогтвортой байдлыг олгож, Монгол Улсын олон улсын нэр хүндийг бүрнээ сэргээн тогтоосон бөгөөд Үндсэн хуулийн гол зорилго нь Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлыг баталгаажуулах, эх орноо хөгжүүлэх, иргэдийнхээ эрх, эрх чөлөө, сайн сайхан аж төрөх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Шинэ Үндсэн хууль өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд Монгол Улсын төрийн тогтолцоо, улс төр, эдийн засаг, нийгмийн харилцаанд эргэлтийн шинжтэй олон шилжилт, өөрчлөлтийг авчирч, хүний эрх, эрх чөлөөний баталгааг олон улсын түвшинд баталгаажуулсан юм. Үндсэн хуулиа баталж, хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийн шинэ тогтолцоонд шилжих шилжилтийг улс төрийн болон эдийн засаг, нийгмийн хүрээнд нэгэн зэрэг хэрэгжүүлснээрээ Монгол Улс бүс нутгийн хэмжээнд төдийгүй олон улсын хамтын нийгэмлэгийн хэмжээнд үлгэр жишээ болж байна хэмээн үнэлэгдэж ирсэн. 1992 оны Үндсэн хууль нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын баталгаа, төрийн байгууллын тогтвортой байдал, эрх мэдэл хоорондын хяналт-тэнцэл, улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын харилцааны бат суурь болж байна. “Иргэд маань Үндсэн хуулиар баталгаажсан эрх, эрх чөлөөгөө эдэлж, өөрийн өмч, үзэл бодол, итгэл

үнэмшилтэй, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх боломжтой, шударгаар хөдөлмөрлөж, нийгмийн халамж дэмжлэг хүртэх, хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх эрхээр хангагдсанд шинэ Үндсэн хуулийн гол ололт, түүхэн ач холбогдол оршиж байна” (*Д.Лүндээжанцан ба Ч.Энхбаатар 2025*).

Монгол Улсын ардчилсан Үндсэн хуулиар баталгаажсан үндсэн хуульт ёс, ард нийтээрээ сонгон байгуулдаг бүгд найрамдах засаглал, төрийн эрх мэдлийн хуваарилалт, хүний эрх, эрх чөлөөний баталгаажилт, иргэний нийгмийн төлөвшил нь тусгаар тогтнолын гол баталгаа, **үндэсний сөрөн тэсвэрлэх хүчин** чадлын нэгэн үндэс нь, Монгол Улсын иргэний эрх, эрх чөлөөний эрх зүйн баталгаа нь мөн. Б.Чимид: Монгол Улсын Үндсэн хууль бол “Монгол эх орны төлөө, Монгол Улсын иргэн бидний төлөө, засаг төрийн дур зоргыг хязгаарласан шударга ёсны төлөө, Монголын ард түмний нийтлэг хүсэл, зоригийг илэрхийлсэн Улсын гол хууль” гэсэн бол Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 16 дугаар зүйлд “Эрхийн баталгааг хангаагүй бөгөөд эрх мэдлийг ялгаж салгаагүй аливаа нийгэмд Үндсэн хууль байхгүй” гэжээ.

Төрөл төрлийн (удам угсааны, дур зоргын, нэр хүндийн (харизматик) цэрэг-цагдаагийн) тоталитар дэглэм, дарангуйллын засаглал хэчнээн хэврэг, төр улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхэд ямар уршигтайг дэлхийн янз бүрийн бүс нутаг дорно дахин арабын ертөнцөд өрнөсөн хэрэг явдал бэлхнээ нотолсоор байна. “Монгол гэрээр зүйрлэвэл унь тооно, хана, хаалга багана, бүслүүр хослон цөм эв номдоо байж улс гэр оршино. “Ухааны чагтага” бөх байвал гэрээ салхинд хийсгэчихгүй, үерт урсгачихгүй, дотроос нь нураачихгүй авч явдаг. Төр улсын маань “ухааны чагтага” нь үндсэн хуульт ёс болой. Монгол Улсад төрийн хууль тогтоомжийн бүх актууд зөвхөн төрийн гол хуульдаа нийцдэг, гол хуулиасаа салбарласан байдаг, Монгол Улсын иргэд хэрэг маргаанаа шударга шүүхээр шийдвэрлүүлдэг, иргэд, төр хуулийн өмнө тэгш байдаг, “хуулиар хориглоогүй бүхэн иргэдэд зөвшөөрөгдсөн байдаг” зэрэг ардчиллын хөдөлшгүй зарчмууд Үндсэн хуулиар баталгаажсан байдаг. Эдүгээ Монгол Улсад үндсэн хуульт ёс, хуулиар засаглахуйн гол баталгаа нь монголын ард түмэн өөрөө, түүний хүсэл зоргын нь илэрхийлэл болж сонгож байгуулсан ардчилсан төрийн тогтолцоо, төрийн эрх мэдлийн хуваарилалт нь юм. Алба, амьдралынхаа алхам бүрийг хуульд захируулж, Үндсэн хуулиа ухаарч мэдэрч, дээдлэн сахих нь Монгол Улсын иргэн бүр, төрийн албат түшээ нарын эрхэм үүрэг. Гэхдээ ардчилсан төрийн эрх мэдлийн бие даасан салаа мөчир нь болох шүүх эрх мэдэл шүүгчид, Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан хараат бус, бие даасан байдал, чиг үүрэг, эрх зүйн байдлаараа Монгол Улсын иргэний эрх эрх чөлөөний халдашгүй дархан байдлын нь нэг онцгой гол баталгаа нь болдог. Энэ бол эдүгээ Монгол Улсад 21 аймаг, нийслэлд бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлж буй давж заалдах шатны 26, анхан шатны 90 шүүх, нийт 500 гаруй шүүгчид монголын ард түмний үүрүүлж буй онцгой үүрэг хариуцлага, итгэл найдвар билээ. Монгол Улсын шүүхэд бас “шударга шүүх” гэсэн гүн утга агуулгатай тодотголтой. Чихнээ чимэгтэй сонсогдох авч энэ эгэл тодотголын цаана нь шүүх, шүүгч нь хэрэг маргааныг шүүхдээ зөвхөн хуулийг түшихийн зэрэгцээ, төрийн хүний “хугаршгүй ноён нуруу” /Ч.Лодойдамба/, шударга үнэний ёс суртахуун, төгс мэдлэг мэргэшилдээ тулгуурласан дотоод итгэл үнэмшлээрээ оновчтой зөв, шударга шийдвэрлэх утга учрыг агуулдаг. Шүүх, шүүгчдийн хэрэг

маргааныг хэрхэн үнэн зөвөөр, шударгаар, шуурхай хянан шийдвэрлэж байгаа нь ардчилсан төрийн маань нэр хүнд, ихэмсэг оршихуйн нэг үндэс нь болдог. Нэгэн зүйлийг онцлоход Монголын түүхийг нүүдэлчин монголчууд хэзээнээс дур зоргоороо аж төрдөг эрхийн соёлгүй гэх мэтээр санаатай, санаагүй мушгин гуйвуулах оролдлого гарсаар иржээ. Энэ тухайд Р.Сайшаал абугай “Чингис хааны нууц товчоон” бүтээлдээ: “Монголчуудад хууль дүрэм байхгүй гэдэг яриа бол монгол үндэстний түүхэн байдлыг мэддэггүй хүмүүсийн дур тавын яриа ба цөөхөн тоот үндэстнийг зэрлэг хөдөөх гэж доромжилдог “лоооэ” нарын чалчаа болно. Түүх шастирыг хянан үзвэл Монгол үндэстэн нэлээд эртнээс хууль дүрэмтэй байжээ ... Чингис хаан шинэхэн байгуулсан Монголын хаант улсыг бэхжүүлэхийн төлөө ... нийгмийн ёс дэглэмийг тогтоож энэхүү төрөлх ... зарлиг, дүрмийг тогтоож нүүдэлчин үндэстнээ хуулиар засахын төлөө Монголын ёс дүрмийн эх товчоог тогтоож, үсэг бичгээр анх удаа тэмдэглэсэн хууль цаазын бичиг “Их Засаг”-ийг байгуулан бүх улсын заргач түшмэлийг томилжээ” гэж няцаалт өгчээ. Энэ бол хуулиар засаглахуй нь Монголын төр улсын төр ёс, хууль цаазын сэтгэлгээний эрхэм нандин уламжлал болохын нотолгоо юм.

ДҮГНЭЛТ: Нэгдүгээрт, Монголын хууль цаазын сэтгэлгээ нь нүүдэлчин соёл иргэншлийн хөрсөнд бүрэлдсэн жам ёсны, хүмүүнлэг шинжтэй эрх зүйн тогтолцоо болох нь батлагдав. Хоёрдугаарт, Чингис хааны “Их Засаг” хууль нь дэлхийн хууль цаазын түүхэнд цогц, дэвшилтэт, олон талт зохицуулалт бүхий үнэт өв мөн. Гуравдугаарт, хууль дээдлэх ёс, шударга ёсны үнэт зүйл нь Монголын төрийн тогтвортой байдлын “ухааны чагтага” болж ирсэн бөгөөд энэ нь орчин үеийн Үндсэн хуульт ёсны гол тулгуур хэвээр байна.

ТАЛАРХАЛ: Энэхүү судалгааг боловсруулахад ашигласан Монголын төр, хууль цаазын түүхийн талаарх дотоод, гадаадын эрдэмтэн судлаачдын бүтээл, түүхэн эх сурвалжуудын зохиогчдод талархал илэрхийлье.

Эшлэл авсан сурвалж, судалгааны бүтээл:

1. Ч.Далай. 2002. “Их Монгол улсыг үндэслэгч Чингис хаан”. *Манай Монгол сэтгүүл* 1-2.
2. Д.Лүндээжанцан, Ч.Энхбаатар. 2025. *Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй*. УБ.
3. Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан. 2021. *Монгол Улсын төр эрх зүйн түүхэн уламжлал*. 3. УБ.
4. И.Дашням нар. 1995. *Эзэн Богд Чингисийн “Их засаг”*. УБ.
5. О.Амархүү. 2022. *Байгаль орчныг хамгаалах монгол занзанил, хууль цааз*. УБ.
6. С.Нарангэрэл. 2021. *Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь*. УБ.
7. Ц.Товуусүрэн. 2024. *Үндсэн хуулиа ойлгохуй*. УБ.
8. Э.Авирмэд, Э.Дашцэдэн, Г.Совд. 1997. *Монгол хууль*. УБ.